



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/378

Номгон

Цагаан таягтны өдрийг тэмдэглэн
өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийг "Дэлхийн цагаан таягтны өдөр" буюу Хараагүй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт үзүүлэх 1.300.000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т даалгасугай.



ДАРГА  Д. МӨНХСАЙХАН

624211471

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар
сарын 24 -ний өдрийн 11/970 дугаар
захирамжийн хавсралт

ЦАГААН ТАЯГТНЫ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН
ТООЦОО

| № | Нэр | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|------|---|------------|----------------|-----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1. | Сургалт, нөлөөллийн арга хэмжээний зардал | 100 | 13.000 | 1.300.000 |
| Нийт | | 1.300.000 | | |

_____ ооо _____